ЮНИСТАР АУДИТ ХХК

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Хай Би Ойл ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

| | |
|---|---|
| Улаанбаатар хот<br>2020 он | Юнистар аудит ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал, аудитор М.Энхжаргал<br>Аудитор: Б.Тэрбиш<br>Утас: 328735<br>Цахим хаяг: info@unistaraudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

*Аудитын код: ЮСА-2020/002/-ХК*

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТУЗ | Төлөөлөн Удирдах Зөвлөл |

## Агуулга

1 Хай Би Ойл ХК-ийн талаарх мэдээлэл ..... 3

2 Хай Би Ойл ХК-ийн ийн 2018 оны жилийн санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай удирдлагын мэдэгдэл ..... 4

3 Аудитын гэрчилгээ ..... 5

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 8

4.1. Санхүүгийн байдлын тайлан ..... 8

4.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан ..... 9

4.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 10

4.4. Мөнгөн гүйлгээний тайлан ..... 11

5 Хай Би Ойл ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дүүсвар болсон жилийн санхүүгийн тайлангийн тэмдэглэл ..... 12

1. Хай Би Ойл ХК-ийн Үндсэн үйл ажиллагааны товч танилцуулга ..... 12

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл ..... 12

3. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл ..... 13

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ..... 13

5. Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 18

## 1 Хай Би Ойл ХК-ийн талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр:

Хай Би Ойл ХК нь анх 2000 онд хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан. 2007 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 41 тоот тогтоолын дагуу хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсан. 2007 оны 12 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж 2615134 тоот регистрийн дугаар бүхий 9010001063 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

---

Гол хувьцаа эзэмшигчид:

| | |
|---|---|
| Нью Альфа ХХК | 33.25% |
| Firebird Mongol Holdings | 18.86% |
| Firebird Global Master Holdings-2 S.A.R.L | 13.01% |
| БиДиСек ХК | 15.79% |
| Монгол Алтан Минт ХХК | 8.00 % |
| Geselect equity fund | 2.58% |
| Zwahr Alexander | 0.78% |
| AFC Umbrella Fund-AFC Asia frontier Fund | 0.58% |
| Хай Би Ойл ХК | 1.89% |
| Yu-Ping Su | 1.01% |
| Бусад жижиг хувьцаа эзэмшигчид | 4.25% |
| | 100.0% |

---

| | | |
|---|---|---|
| Төлөөлөн Удирдах Зөвлөл: | Ц.Батбаяр | ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн |
| | Б.Батбаатар | ТУЗ-ийн гишүүн |
| | А.Батбаяр | ТУЗ-ийн гишүүн |
| | Б.Мянганбаяр | ТУЗ-ийн гишүүн |
| | Ж.Эрдэмбилэг | ТУЗ-ийн гишүүн |
| | С.Ариунбат | ТУЗ-ийн гишүүн |
| | Б.Лхагвадорж | ТУЗ-ийн гишүүн |
| | А.Харцага | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Т.Тамир | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гүйцэтгэх удирдлага | Ш.Амар-Отгон | Гүйцэтгэх захирал |

---

Хаяг: Хай Би Ойл ХК, Сонсголонгийн /18135/-110, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар Хороо, Улаанбаатар хот, Монгол Улс.

---

Аудитор: Юнистар аудит ХХК
Мигма Төв 306 тоот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,
Улаанбаатар хот, Монгол Улс

---

UniStar-Audit LLC

ACCOUNTING, AUDITING, ASSURANCE, CONSULTING, VALUATION AND TAX SERVICE

СБД, 8-р хороо, Амарын гудамж,
Мигма төв 306 тоот
Утас: 3287358 99168961, 99994372
E-mail: info@unistaraudit.mn

2020.04.07 № 20/17
Танай_________№__________

ХАЙ БИ ОЙЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭД

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Бид Хай Би Ойл ХК-ийн 2019 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар, **Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл** хэсэгт дурдсан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Хай Би Ойл ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох заавар, журмын дагуу бусад бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бодитой толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Компанийн удирдлага, энэхүү **аудитын тайлангийн тодруулга 5 - Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт**-д багтсан Сингапур улсын хуулийн этгээд "Блектип Энержи Лимитед" компанийн, нэг бүр нь 0.36 сингапур долларын үнэтэй 3,633,450 ширхэг энгийн хувьцаа (нийт энгийн хувьцааны 13%)-нд оруулсан хөрөнгө оруулалтад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр аливаа үнэ цэнийн бууралтыг бүртгээгүй байна. Блектип Энержи Лимитед компанийн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хурлаар компанийг татан буулгах онцгой шийдвэр гаргасан талаар **аудитын тайлангийн тодруулга 17-д дурдсан** ба компани энэ хөрөнгө оруулалтаас 1,636,952.1 мянган төгрөгийн алдагдал хүлээж болзошгүй байна.

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт(АОУС)-д нийцүүлэн гүйцэтгэсэн. Эдгээр стандартын дагуу бидний хүлээх хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх хариуцлага хэсэгт тодорхойлсон болно. Бид Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд хуулиар шаардсан ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)**

**Онцлох асуудал**

Санхүүгийн тайлангийн **Санхүүгийн тайлангийн тодруулга 16** - Болзошгүй алдагдал хэсэгт дурдсан Ашид мөнхийн зам ХХК-иас авах нийт 108,745.2 мянган төгрөгийн авлага эргэн төлөгдөх эсэх нь Хай Би Ойл ХК-ийн удирдлагын үйл ажиллагаанаас хамаарахаар байгааг энэхүү санхүүгийн тайлан хэрэглэгчдийн анхааралд хүргэж байна. Бид энэхүү авлагатай холбоотойгоор дээр гаргасан дүгнэлтийн хэлбэрийг өөрчлөөгүй болно.

**Бусад мэдээлэл**

Компанийн удирдлага бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд ордог мэдээллээс бүрддэг болович түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайлангийн талаар гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажуулалт, дүгнэлт гаргахгүй.

Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бусад мэдээллийг уншиж, санхүүгийн тайлан, аудитаар олж авсан бидний мэдлэг, мөн өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай асуудлыг авч үздэг. Бид өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажилдаа суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл энэ тухай тайландаа тусгах ёстой. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

**Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Залит ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, үйл ажиллагаагаа зогсоох эсвэл ингэхээс өөр сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба шаардлагатай бол тасралтгүй байдалтай холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Мөн засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

**Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд нь залы мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгааг олж авах, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах явдал юм. Ул үндэслэлтэй баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа болович АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчил бүрийг ямагт илрүүлнэ гэсэн баталгаа гаргадаггүй. Залы мэх эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр суурьнаас хандаж мэргэжлийн шийдэл гарган ажилласан. Мөн:

- Залы мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын

ЮНИСТАР АУДИТ ХХК БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН АЛБАЛТЫН НЭГЖИЙН

горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн үгсэн хуйвалдах, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох зэргээс шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэстэй байдлыг үнэлдэг.
- Мөн компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадамжинд мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байдлын суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ компанийн тасралтгүй байх чадавхид нөлөөлөх нөхцөл байдал, үйл явдал ирээдүйд үүсч болох юм.
- Санхүүгийн тайлангийн толилуулга, бүтэц, агуулга, тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Бид аудитын цар хүрээ, хугацаа, аудитын явцад олж илрүүлсэн томоохон чухал асуудлууд болон ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар эрх бүхий удирдлагатай харилцдаг.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Хай Би Ойл ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн.

М.ЭНХЖАРГАЛ

Юнистар Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2020.04.02

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1. Санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | 2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| ХӨРӨНГӨ | | |
| Эргэлтийн хөрөнгө | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 51,945,419.62 | 252,039,809.91 |
| Дансны авлага | 1,500,438,003.91 | 1,464,897,503.00 |
| Татвар, НДШ-ийн авлага | 13,982,552.65 | 3,491,190.86 |
| Бусад авлага | 483,890,994.60 | 492,944,178.30 |
| Бараа материал | 123,568,284.77 | 134,310,757.74 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 39,205,502.86 | 20,610,324.63 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **2,213,030,758.41** | **2,368,293,764.44** |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 1,187,285,930.40 | 1,042,595,730.08 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,636,952,132.00 | 1,691,233,612.00 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **2,824,238,062.40** | **2,733,829,342.08** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,037,268,820.81** | **5,102,123,106.52** |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | | |
| ӨР ТӨЛБӨР | | |
| Богино хугацаат өр төлбөр | | |
| Дансны өглөг | 302,633,872.28 | 228,287,741.85 |
| Цалингийн өглөг | 129,136,875.43 | 129,136,875.43 |
| Татварын өр | 2,558,484.28 | 6,900,599.55 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 117,809,055.00 | 117,436,140.00 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **552,138,286.99** | **481,761,356.83** |
| Хойшлогдсон татварын өр | 71,449,317.58 | 78,003,580.38 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **71,449,317.58** | **78,003,580.38** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **623,587,604.57** | **559,764,937.21** |
| Эздийн өмч | | |
| Өмч-хувьцаат | 5,211,895,400.00 | 5,211,895,400.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | 4,592,503,138.14 | 4,592,503,138.14 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (5,390,717,321.90) | (5,262,040,368.83) |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **4,413,681,216.24** | **4,542,358,169.31** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | **5,037,268,820.81** | **5,102,123,106.52** |



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН

## 4.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тэм | 2018 оны дүн | 2019 оны дүн |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого (цэвэр) | | 950,149,642.90 | 760,366,545.50 |
| Борлуулсан бүтээгдхүүний өртөг | | 629,251,222.82 | 415,669,385.81 |
| Нийт ашиг (алдагдал) | | 320,898,420.08 | 344,697,159.69 |
| Хүүгийн орлого | | 1,719,461.78 | 2,107,353.32 |
| Бусад орлого | | 180,000.50 | 381,020.73 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | | 282,087,814.78 | 268,956,468.06 |
| Бусад зардал | | (4,207,520.96) | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | 156,114,971.65 | 65,542,628.04 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | | (706,403.18) |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | | 192,617,518.27 | 143,065,290.54 |
| Орлогын татварын зардал-Орлогын татвар | | 3,924,070.42 | 8,044,074.67 |
| Хойшлогдсон орлогын албан татварын зардал | | 15,611,497.16 | 6,554,262.80 |
| Татварын дараах ашиг алдагдал | | 173,081,950.69 | 128,466,953.07 |
| Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | | 173,081,950.69 | 128,466,953.07 |
| **Орлогын нийт дүн** | | **173,081,950.69** | **128,466,953.07** |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | 3.32 | 2.46 |



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН

## 4.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2017 оны 12 сарын 31 - нээрх үлдэгдэл | 5,211,895,400.00 | 4,592,503,138.14 | (5,564,898,612.59) | 4,239,499,925.55 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | - |
| Залруулсан үлдэгдэл | 5,211,895,400.00 | 4,592,503,138.14 | (5,564,898,612.59) | 4,239,499,925.55 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | 173,081,950.69 | 173,081,950.69 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | 1,099,340.00 | 1,099,340.00 |
| 2018 оны 12 сарын 31 - нээрх үлдэгдэл | 5,211,895,400.00 | 4,592,503,138.14 | (5,390,717,321.90) | 4,413,681,216.24 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | 210,000.00 | 210,000.00 |
| Залруулсан үлдэгдэл | 5,211,895,400.00 | 4,592,503,138.14 | (5,390,507,321.90) | 4,413,891,216.24 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | 128,466,953.07 | 128,466,953.07 |
| 2019 оны 12 сарын 31 | 5,211,895,400.00 | 4,592,503,138.14 | (5,262,040,368.83) | 4,542,358,169.31 |



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ

## 4.4. Мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тэм | 2018 оны дүн | 2019 оны дүн |
|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллгааны мөнгөн гүйлгээ | | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | | 1,065,091,750.00 | 913,261,807.00 |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | | 1,065,091,750.00 | 913,261,807.00 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага | | (1,023,803,869.22) | (715,265,114.82) |
| Ажиллагчдад төлсөн | | (164,968,285.20) | (132,930,747.92) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | | (50,907,245.05) | (38,860,576.38) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | | (380,015,950.00) | (294,142,937.37) |
| Ашиглалтын зардлад төлсөн | | (4,658,600.00) | (22,278,000.00) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | | (970,000.00) | (25,273,717.56) |
| Хүүний төлбөрт төлсөн | | 0.00 | 0.00 |
| Татварын байгууллагад төлсөн | | (183,065,825.16) | (78,546,047.69) |
| Даатгалын төлбөрт төлсөн | | 0.00 | (289,332.00) |
| Бусад мөнгөн зарлага | | (239,217,963.81) | (122,943,755.90) |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | 41,287,880.78 | 197,996,692.18 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | | 1,420,342.85 | 2,089,353.32 |
| Хүлээн авсан хүүний орлого | | 1,420,342.85 | 2,089,353.32 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | | (4,430,000.00) | - |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | (4,430,000.00) | - |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | (3,009,657.15) | 2,089,353.32 |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | | - | 8,553.48 |
| Валютын ханшийн ашиг | | | 8,553.48 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | | 26,196.91 | (208.69) |
| Валютын ханшийн ашиг/алдагдал | | 26,196.91 | (208.69) |
| Санхүүгийн ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | 26,196.91 | 8,344.79 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | | 38,304,420.54 | 200,094,390.29 |
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 13,640,999.08 | 51,945,419.62 |
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 51,945,419.62 | 252,039,809.91 |



ЮНИСТАР АУДИТ ХХК БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН

## 5 Хай Би Ойл ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлангийн тэмдэглэл

### 1. Хай Би Ойл ХК-ийн үндсэн үйл ажиллагааны товч танилцуулга

Хай Би Ойл ХК нь 2007 оноос эхлэн ашигласан техникийн тосыг дахин цэвэршүүлэх Хонгконгийн Dunwell группийн VSEP технологийн VMAT I-36 системийн үйлдвэрийг ашиглалтанд оруулсан. Үйлдвэр сард 200 тонн нефтийн гаралтай ашигласан тос боловсруулах хүчин чадалтай бөгөөд мазут, гидрийн шингэн, тос тосолгооны материал зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Хай Би Ойл ХК нь Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт өөрийн байранд үйлдвэрлэлээ явуулж байна.

### 2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

Хай Би Ойл ХК-ийн удирдлага нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу компанийн хөрөнгө, эх үүсвэр, санхүүгийн байдал, хүлээн зөвшөөрсөн орлого, зарлага, тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Хай Би Ойл ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын сатандартын Хорооноос гаргаж, мөрдүүлсэн СТОУС болон Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэгдсэн байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын тухай мэдээллийг Тэмдэглэл 4-д оруулсан. Холбогдох хэсэгт тусгайлан зааснаас бусад тохиолдолд Тэмдэглэл 4-д заасан бодлогуудыг хэрэглэсээр ирсэн.

Компанийн тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт "төгрөг" байна.

Санхүүгийн тайлангууд нь доорхи зүйлсээс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

-Санхүүгийн хэрэглүүр – Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжих

- Санхүүгийн хөрөнгө – Зээл ба авлага

- Санхүүгийн өр төлбөр – Хорогдуулсан өртгөөр илэрхийлэх

Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Тус компани 2007 онд хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсанаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах бодлого, стратегитай ажиллаж байгаа бөгөөд компанийн үйлдвэрлэл борлуулалт, зах зээл өргөжих хандлагатай байна. Компанийн санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд тулгуурлан бэлтгэгдсэн.

Хай Би Ойл ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандартын Хорооноос гаргаж, мөрдүүлсэн СТОУС болон Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэгдсэн байна.

Хай Би Ойл ХК санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Interactive Diamond ERP" програм хангамж ашигладаг.



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН

## 3. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг.

Компани ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны талаарх таамаглал гэх мэт бусад хүчин зүйлд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтанд суурилан тайлант үе бүрийн эцэст барилга байгууламж, тоног төхөөрөмж, компютер дагалдах хэрэгсэл болон биет бус хөрөнгө зэрэг элэгдүүлдэг хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

Бараа материал

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар тусгана. Цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо тооцоолол хийх үеийн хамгийн найдвартай бэлэн байгаа нотолгоог авч үздэг. Компанийн бизнес нь технологийн өөрчлөлттэй нягт уялдаатай бол борлуулалтын үнэ нь хурдан өөрчлөгдөж байдаг. Бараа материалын дансны үнийн ирээдүйд гарах өөрчлөлт нь зах зээлийн үнийн өөрчлөлтөөс шалтгаална.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгж тус бүрийн хувьд аливаа үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тодорхойлдог. Тухайн хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийг ашиглах ба худалдан борлуулснаас бий болох бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнээс бага байх тохиолдолд үнэ цэнийн бууралтыг авч үздэг. Бодит үнэ цэнэ нь тухайн арилжааны талаар зохих мэдлэг бүхий оролцогч эсвэл сонирхогч талуудын хоорондын хөрөнгөө худалдах, солилцох тохиролцсон үнээр тодорхойлогдоно.

Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах болон тавар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

## 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

### a) Санхүүгийн хөрөнгө

***Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө***

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, 3 сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай, үнийн өөрчлөлтөнд өртөмтгий бус хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана.

***Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт***

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхны хүлээн



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН
ШАЛГАЛСАН

зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэд ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ажил гүйлгээний зардлыг тайлант үеийн ашиг алдагдлаар тайлагнана.

***Ангилал***

Санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд хэмжих зорилгоор дараах байдлаар ангилна.

i. Зээл ба авлага
   Зээл ба авлагууд нь идэвхитэй зах зээлийн жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгө юм.
ii. Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө
   Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө нь арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан аваад богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай хөрөнгө болон анхнаасаа бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгүүд юм.
   Идэвхитэй зах зээлийн жишиг байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх хөрөнгө гэж ангилахгүй.

***Дараа үеийн хэмжилт***

Зээл ба авлага, дуусах хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө болон бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд бодит үнэ цэнээр хэмжинэ. Бодит үнэ цэнээс үүссэн олз, гарзыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ✓ Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдлын тайланд бусад орлого, бусад зардлаар
- ✓ Гадаад валютаар илэрхийлсэн үнэт цаас бүхий борлуулах боломжтой хөрөнгийн хувьд үнэт цаасны хорогдуулсан өртөгт орсон өөрчлөлттэй холбоотой үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар, дансны үнийн бусад өөрчлөлтийг дэлгэрэнгүй орлогоор
- ✓ Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж ангилсан мөнгөн болон мөнгөн бус үнэт цаасны хувьд бусад дэлгэрэнгүй орлогоор,

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүгийн орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана. Үр ашигт хүүгийн аргаар тооцсон борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө, дуусах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт болон зээл, авлагын хүүг ашигт, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

***Үл хүлээн зөвшөөрөлт***

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалын хүлээн авах эрхийн хугацаа дууссан, эсвэл
- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд (а) санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж бүрэн шилжсэн, эсвэл (б) бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг нь шилжүүлсэн байх.

***Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт***

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой бууралт байгаа бол уг хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

**i) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө**

Зээл ба авлагын хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн



ЮНИСТАР АУДИТ ХХК БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН

бууралтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар бүртгэнэ.

**ii) Борлуулах боломжтой хөрөнгө**

Борлуулах боломжтой хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүгээр хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацаанд ашиг алдагдал руу буцаахгүй.

Борлуулах боломжтой хөрөнгө гэж ангилсан өрийн үнэт цаасны бодит үнэ цэнэ дараагийн үеүдэд өссөн бол уг өсөлт нь өмнөх хугацаанд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дараа тохиолдсон үйл явдлаас хамаарсан эсэхийг тодорхойлж, ашиг алдагдлыг буцаана.

**b) Санхүүгийн өр төлбөр**

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилна:

- ✓ Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ✓ Бусад санхүүгийн өр төлбөр

***Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр***

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэ ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг. Үүнээс бусад арилжаалагдах, эсвэл үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

***Бусад санхүүгийн өр төлбөр***

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- ✓ Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг тайлангийн үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана.
- ✓ Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

**c) Үндсэн хөрөнгө**

***Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт***

Үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдэл хассан цэвэр дүнгээр тайлагнагдсан. Түүхэн өртөг нь худалдан авахтай холбоотой зардлаас бүрдэнэ. Үндсэн хөрөнгөд барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер бусад хэрэгсэл болон бусад хөрөнгө бүртгэгдсэн байна. Үндсэн хөрөнгийг данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТЭС ЗӨВШӨӨРСӨН

дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлж, орлогын тайланд ашиг, алдагдлаар тусгана.

***Элэгдэл***

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг.

**d) Эздийн өмч**

Энгийн хувьцааг өмчөөр бүртгэсэн. Хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн дүнг нэмж төлөгдсөн капиталаар бүртгэсэн.

Хуримтлагдсан ашиг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашиг хуваарилсны дараа үлдэж буй цэвэр ашиг юм.

**e) Орлого**

Эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон үед орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэх ба аливаа хөнгөлөлт, буцаалт болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр нь тайланд тусгана.

Хүүний орлого

Хүүний орлогыг үндсэн зээл буюу хэрэглүүрийн үлдэгдэл болон холбогдох харилцах хадгаламжийн үлдэгдэл, үр ашигт хүүний түвшнээр тооцож, аккруэл суурьиар хүлээн зөвшөөрнө.

**f) Өртөг ба Зардал**

Хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг орлогын нэгэн адил аккурэл суурьиар бүртгэсэн. Зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үндсэн бус үйл ажиллагааны зардал ба гарз гэж ангилж бүртгэсэн. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь борлуулалтын орлогод ногдох бүтээгдэхүүний өртөг юм.

Өртөг зардлыг тайлант хугацааны ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

**g) Санхүүгийн орлого, зардал**

Санхүүгийн орлогод харилцах, хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүүний орлого болон бусад холбоотой талуудад олгосон зээлийн хүүний орлого, богино хугацаат бондын хүүний орлого зэргийг хамруулна. Хүүний орлогыг олсон тайлант үеийнх орлогын тайланд тусгана.

Зээлийн хүүний зардал

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах эсвэл үйлдвэрлэлтэй шууд холбоотой зээлийн хүүгийн зардлыг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгох зорилгоор хөрөнгийг бэлтгэх болон бүрэн дуусгахад шаардлагатай хугацааны туршид капиталжуулна. Бэлтгэх ажиллагаа шаардлагатай хөрөнгө гэдэг нь хөрөнгийг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болтол тодорхой хугацаа шаардлагатай хөрөнгө юм.

**h) Ханшийн зөрүүг хүлээн зөвшөөрөх**

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон авлага, өглөгийг тайлагналын өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН

Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээг гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Хөрвүүлэлтээс үүдэлтэй гадаад валютын ханшийн зөрүү нь орлогын тайланд тайлагнагдсан.

**i) Татварын бүртгэл**

***Орлогын албан татвар***

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэгжиж байсан хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн татварын зардал болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн жилд эсвэл өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэснээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зардалд хүлээн зөвшөөрөгдөнө.

***Хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөр***

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлангийн зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм.

Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Ирээдүйд татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулна.

**j) Холбоотой талууд**

Компанид дараах талуудыг холбоотой талууд гэж үздэг.

а. Компанийн шууд эсвэл шууд бусаар хянадаг эсвэл хянагддаг, эсвэл нэгдсэн хяналтанд багтдаг компаниуд,

б. Хараат компаниуд,

в. Компанийн саналын эрхтэй хувьцааг шууд эсвэл шууд бусаар эзэмшиж томоохон нөлөө үзүүлдэг хувь хүмүүс эсвэл тэдгээр хувь хүмүүсийн гэр бүлийн гишүүд,

г. Компанийн үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, хянах эрх ба үүрэгтэй удирдлагын гол ажилтнууд, үүнд компанийн захирлууд ба удирдах ажилтнууд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд,

д. Компанийн саналын эрхтэй хувьцааны дийлэнх хувийг шууд эсвэл шууд бусаар эзэмшдэг (в) ба (г)-д тодорхойлсон хувь хүмүүс эсвэл тэдгээр хүмүүс нь томоохон нөлөө үзүүлдэг. Компанийн гол удирдлагад нэг гишүүн нь болж байгаа компаниуд мөн багтана.

**k) Болзошгүй зүйлс**

Хэрэв өнгөрсөн үйл явдлын үр дүнгээс хамааран компани нь хууль ёсны эсвэл практик үүрэг хариуцлагыг хүлээж байгаа бөгөөд энэ хариуцлагыг зохих ёсоор тодорхойлох боломжтой ба эдийн засгийн үр өгөөжөөр уг хариуцлагыг барагдуулах боломжтой үед болзошгүй зүйлсийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН
НЭГТГЭМЖЛЭГДСЭН

## 5. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 1) Тодруулга - Мөнгөн хөрөнгө

/төгрөгөөр/

| | Валютын төрөл | 2018/12/31 | | 2019/12/31 | | Өөрчлөгдсөн дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гадаад валютаар | Төгрөгөөр | Гадаад валютаар | Төгрөгөөр | Гадаад валютаар | Төгрөгөөр |
| **Касс дахь бэлэн мөнгө** | | | | | | | |
| Касс | MNT | | 298,103.00 | | 109,051.00 | - | (189,052.00) |
| Дүн | | - | **298,103.00** | - | **109,051.00** | - | **(189,052.00)** |
| **Банкны харилцах дансан дахь мөнгө** | | | | | | | |
| Худалдаа хөгжлийн банк | MNT | | 51,134,981.07 | | 251,484,162.82 | - | 200,349,181.75 |
| Худалдаа хөгжлийн банк | USD | 98.54 | 260,433.34 | 94.03 | 257,032.89 | (4.51) | (3,400.45) |
| Худалдаа хөгжлийн банк | EURO | 62.59 | 189,563.20 | 62.59 | 189,563.20 | - | - |
| Капитрон банк | MNT | | 14,000.00 | | - | - | (14,000.00) |
| Капитрон банк | USD | 18.29 | 48,339.01 | | - | (18.29) | (48,339.01) |
| Дүн | | | **51,647,316.62** | | **251,930,758.91** | | **200,283,442.29** |
| **Мөнгөн хөрөнгийн нийт дүн** | | | **51,945,419.62** | - | **252,039,809.91** | | **200,094,390.29** |

### 2) Тодруулга - Авлага

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | Харилцагч-дын тоо | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Дансны авлага | 1,994,379,708.91 | 1,958,839,208.00 | 7 | (35,540,500.91) | (1.81) |
| Найдваргүй авлагын нөөц | (493,941,705.00) | (493,941,705.00) | | - | - |
| Татварын авлага | 13,982,552.65 | 3,491,190.86 | 1 | (10,491,361.79) | (300.51) |
| Бусад авлага | 483,890,994.60 | 492,944,178.30 | 3 | 9,053,183.70 | 1.84 |
| Дүн | 1,998,311,551.16 | 1,961,332,872.16 | 11 | (36,978,679.00) | (1.89) |

### а. Дансны авлага

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Валютын төрөл | 2018/12/31 | | 2019/12/31 | | Өөрчлөгдсөн дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гадаад валютаар | Төгрөгөөр | Гадаад валютаар | Төгрөгөөр | Гадаад валютаар | Төгрөгөөр |
| **Борлуулалтын авлага** | | | | | | | |
| Байгууллагаас авах авлага | MNT | | 141,161,109.00 | | 120,815,168.00 | - | (20,345,941.00) |
| Хүмүүсээс авах авлага | MNT | | 96,998,259.91 | | 21,600,000.00 | - | (75,398,259.91) |
| Дүн | | - | **238,159,368.91** | - | **142,415,168.00** | - | **(95,744,200.91)** |
| **Валютаарх авлага** | | | | | | | |
| Зээлийн авлага | USD | 664,500 | 1,756,220,340.00 | 664,500 | 1,816,424,040.00 | - | 60,203,700.00 |
| Дүн | | | **1,756,220,340.00** | | **1,816,424,040.00** | | **60,203,700.00** |
| **Найдваргүй авлагын хасагдуулга** | | | | | | | |
| Найдваргүй авлагын хасагдуулга | | | **(493,941,705.00)** | | **(493,941,705.00)** | | - |
| Дүн | | - | **(493,941,705.00)** | - | **(493,941,705.00)** | - | - |
| **Дансны авлагын дүн** | | | **1,500,438,003.91** | - | **1,464,897,503.00** | | **(35,540,500.91)** |

### б. Бусад авлага

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Валютын төрөл | 2018/12/31 | | 2019/12/31 | | Өөрчлөгдсөн дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гадаад валютаар | Төгрөгөөр | Гадаад валютаар | Төгрөгөөр | Гадаад валютаар | Төгрөгөөр |
| **Бусад авлага** | | | | | | | |
| Байгууллагаас авах авлага | MNT | | 108,752,445.44 | | 104,945,780.00 | - | (3,806,665.44) |
| Хүмүүсээс авах авлага | MNT | | | | | - | - |
| Дүн | | - | **108,752,445.44** | - | **104,945,780.00** | - | **(3,806,665.44)** |
| **Валютаарх авлага** | | | | | | | |
| Зээлийн хүүгийн авлага | USD | 141,940.94 | 375,138,549.16 | 141,940.94 | 387,998,398.30 | - | 12,859,849.14 |
| Дүн | | | **375,138,549.16** | | **387,998,398.30** | | **12,859,849.14** |
| **Бусад авлагын дүн** | | | **483,890,994.60** | - | **492,944,178.30** | | **9,053,183.70** |

3 байгууллагатай холбоотой 104,945,8 мянган төгрөгийн, 2 байгуулагатай холбоотой 141.9 мянган америк долларын хүүгийн авлага барагдахгүй 2-6 жил болж байна.

Шарын гол ХК-иас 664,500 америк долларын зээлийн, 123,017.26 америк долларын зээлийн хүүгийн, 10,866,254 төгрөгийн дансны, 45,320,783 төгрөгийн бусад авлагатай. Энэ асуудлаар компани шүүхэд нэхэмжлэл гаргасан ба авлагадаа Шарын гол ХК-ийн нэг бүр нь 1,929.32 төгрөгийн үнэ бүхий 1,139,627 ширхэг хувьцаа авахаар эвлэрлийн гэрээ байгуулсан байна.

2014 онд Ашид Мөнхийн зам ХХК-д нийлүүлсэн бүтээгдэхүүний үлдэгдэл төлбөр 57,016,867 төгрөгийн авлага болон валютын зээлийн 18,923.68 америк долларын хүүний авлагыг барагдуулаагүй байна. Ашид Мөнхийн зам ХХК үндсэн зээлээ төлсөн боловч зээлийн хүүг төлөөгүй байна.

## 3) Тодруулга - Бараа материал

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | Гүйлгээ | | 2019/12/31 -ний үлдэгдэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдсэн | хасагдсан | | Дүн | Хувь |
| Түүхий эд материал | 122,059,863.87 | 673,742,292.86 | 712,447,551.09 | 83,354,605.64 | (38,705,258.23) | (46.43) |
| Дуусаагүй үйлдвэрлэл | - | 519,372,833.67 | 519,372,833.67 | - | - | - |
| Бэлэн бүтээгдэхүүн | 1,508,420.90 | 574,855,988.53 | 525,593,257.33 | 50,771,152.10 | 49,262,731.20 | 97.03 |
| Сав баглаа боодол | - | 500,000.00 | 315,000.00 | 185,000.00 | 185,000.00 | 100.00 |
| Дүн | 123,568,284.77 | 1,768,471,115.06 | 1,757,728,642.09 | 134,310,757.74 | 10,742,472.97 | 8.00 |

## 4) Тодруулга - Урьдчилж төлсөн зардал тооцоо

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | Харилцагч-дын тоо | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Урьдчилж төлсөн тооцоо | 33,290,693.40 | 17,634,821.32 | 7 | (15,655,872.08) | (88.78) |
| Дараа тайлангийн тооцоо | 5,669,174.00 | 1,647,167.40 | | (4,022,006.60) | (244.18) |
| Шатахууны картын тооцоо | 245,635.46 | 1,328,335.91 | 1 | 1,082,700.45 | 81.51 |
| Дүн | 39,205,502.86 | 20,610,324.63 | 8 | (18,595,178.23) | (90.22) |

## 5) Тодруулга - Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | Харилцагч-дын тоо | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт | 1,636,952,132.00 | 1,691,233,612.00 | 2 | 54,281,480.00 | 3.21 |
| Дүн | 1,636,952,132.00 | 1,691,233,612.00 | 2 | 54,281,480.00 | 3.21 |



ЮНИСТАР АУДИТ ХХК БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

Сингапур улсын хуулийн этгээд болох Блектип Энержи Лимитед (нэрээ өөрчлөхөөс өмнөх нэр Нинокс Энержи Лимитед) компанийн нэг бүр нь 4.0 сингапур долларын үнэтэй А зэрэглэлийн энгийн хувьцаанд хөрвөх боломжтой, саналын эрхтэй, үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх ногдол ашиг авах нөхцөлтэй 322,286 ширхэг давуу эрхийн хувьцааг эзэмшиж байсан ба 2016 онд ногдол ашгийг нэмсэн дүнгээр нэг бүр нь 0.36 сингапур долларын үнэтэй 3,633,450 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлсэн. Энэ нь Блектип Энержи Лимитед компанийн нийт энгийн хувьцааны 13 хувь бөгөөд тайлант онд хувьцаа эзэмшигчид шаардлагатай мэдээлэл аваагүй, улмаар үнэ цэнийг тодорхойлоогүй байна. Блектип Энержи Лимитед компанийн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хурлаар компанийг татан буулгах санал гаргаж, Грант торнтон Сингапур компанийн 2 хүнийг татан буулгагчаар томилсон байна. Компанийн татан буулгагчдад Сингапур улсын Компанийн тухай хуулийн дагуу компанийн хөрөнгийн тодорхой хэсгийг гишүүдэд бодит хэлбэрээр хуваарилах эрх олгосон байна.

2019 онд өмнөх гүйцэтгэх захирал Ө.Хүдрээгээс авах авлагадаа Хай би ойл ХК-ийн 54,281,480 төгрөгийн үнэ бүхий хувьцаа авсаныг хувьцаагаарх хөрөнгө оруулалт дансанд бүртгэсэн.

### 6) Тодруулга - Үндсэн хөрөнгө

/төгрөгөөр/

| Ангилал | Тайлбар | 2018/12/31-ний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хасагдсан | 2019/12/31-ний үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| Барилга байгууламж | Хөрөнгө | 1,170,046,810.76 | 19,500,000.00 | | 1,189,546,810.76 |
| | Хуримтлагдсан элэгдэл | 227,085,058.96 | 61,441,515.99 | | 288,526,574.95 |
| Машин тоног төхөөрөмж | Хөрөнгө | 263,509,371.00 | | 2,000,000.00 | 261,509,371.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | 188,978,630.16 | 54,594,218.38 | 1,499,868.39 | 242,072,980.15 |
| Тээврийн хэрэгсэл | Хөрөнгө | 208,800,000.00 | | | 208,800,000.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | 66,792,558.87 | 43,504,574.04 | | 110,297,132.91 |
| Тавилга, эд хогшил | Хөрөнгө | 6119436.52 | | 1,678,936.52 | 4,440,500.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | 4,258,507.03 | 946,407.91 | 1,480,164.95 | 3,724,749.99 |
| Компьютер дагалдах хэрэгсэл | Хөрөнгө | 20,963,747.04 | 520,000.00 | 14,829,447.04 | 6,654,300.00 |
| | Хуримтлагдсан элэгдэл | 19,424,540.48 | 1,565,818.18 | 14,829,447.04 | 6,160,911.62 |
| Бусад үндсэн хөрөнгө | Хөрөнгө | 55,655,835.50 | 10,930,000.00 | 10,079,244.59 | 56,506,590.91 |
| | Хуримтлагдсан элэгдэл | 31,269,974.92 | 12,881,262.64 | 10,071,744.59 | 34,079,492.97 |
| **НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | **ХӨРӨНГӨ** | **1,725,095,200.82** | **30,950,000.00** | **28,587,628.15** | **1,727,457,572.67** |
| | **ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ** | **537,809,270.42** | **174,933,797.14** | **27,881,224.97** | **684,861,842.59** |
| **НИЙТ ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ** | | **1,187,285,930.40** | **(143,983,797.14)** | **706,403.18** | **1,042,595,730.08** |



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН

## 7) Тодруулга - Богино хугацаат өр төлбөр

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | Харилцагч-дын тоо | Өөрчлөлт Дүн | Өөрчлөлт Хувь |
|---|---|---|---|---|---|
| Дансны өглөг | 302,633,872.28 | 228,287,741.85 | 3 | (74,346,130.43) | (32.57) |
| Цалингийн өглөг | 129,136,875.43 | 129,136,875.43 | | - | - |
| Татварын өглөг | 2,558,484.28 | 6,900,599.55 | 1 | 4,342,115.27 | 62.92 |
| Бусад өглөг | 117,809,055.00 | 117,436,140.00 | 3 | (372,915.00) | (0.32) |
| Дүн | 552,138,286.99 | 481,761,356.83 | 7 | (70,376,930.16) | (14.61) |

## 8) Тодруулга – Урт хугацаат өр төлбөр

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | | Өөрчлөлт Дүн | Өөрчлөлт Хувь |
|---|---|---|---|---|---|
| Хойшлогдсон татварын өр | 71,449,317.58 | 78,003,580.38 | | 6,554,262.80 | 8.40 |
| Дүн | 71,449,317.58 | 78,003,580.38 | - | 6,554,262.80 | 8.40 |

Хойшлогдсон татварын өглөг нь гадаад валютын ханшийн хэрэгжээгүй түр зөрүүгээс үүссэн.

## 9) Тодруулга - Өөрийн хөрөнгө

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 | 2019/12/31 | | Өөрчлөлт Дүн | Өөрчлөлт хувь |
|---|---|---|---|---|---|
| Энгийн хувьцаа | 5,211,895,400.00 | 5,211,895,400.00 | 373 | - | 100.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | 4,592,503,138.14 | 4,592,503,138.14 | | - | 100.00 |
| Хуримтлагдсан алдагдал | (5,390,717,321.90) | (5,262,040,368.83) | | 128,676,953.07 | 97.61 |
| Дүн | 4,413,681,216.24 | 4,542,358,169.31 | 373 | 128,676,953.07 | 102.92 |

### 10) Тодруулга – Борлуулалтын орлого

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| | | | | - | |
| Мазутын борлуулалт | 950,149,642.90 | 759,051,818.23 | | (191,097,824.67) | (25.18) |
| Бусад борлуулалт | - | 1,314,727.27 | | 1,314,727.27 | 100.00 |
| | | | | - | #DIV/0! |
| Дүн | 950,149,642.90 | 760,366,545.50 | - | (189,783,097.40) | (24.96) |

### 11) Тодруулга – Борлуулалтын өртөг

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| | | | | - | |
| Мазутын өртөг | 629,251,222.82 | 415,669,385.81 | | (213,581,837.01) | (51.38) |
| Дүн | 629,251,222.82 | 415,669,385.81 | - | (213,581,837.01) | (51.38) |

### 12) Тодруулга-Үйл ажиллагааны зардал

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018 он | 2019 он | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Ажилчдын цалингийн зардал | 103,100,255.63 | 69,544,382.91 | (33,555,872.72) | 67.45 |
| ААН-ээс төлсөн НДШ*-ийн зардал | 14,335,962.32 | 10,092,960.84 | (4,243,001.48) | 70.40 |
| Томилолтын зардал | 4,354,400.00 | | (4,354,400.00) | - |
| Бичиг хэрги йн зардал | 1,517,426.35 | 1,438,858.72 | (78,567.63) | 94.82 |
| Шуудан холбооны зардал | 2,244,742.35 | 1,621,909.06 | (622,833.29) | 72.25 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 57,762,328.36 | 14,181,818.18 | (43,580,510.18) | 24.55 |
| Сургалтын зардал | | 136,363.64 | 136,363.64 | - |
| Даатгалын зардал | - | 261,281.82 | 261,281.82 | - |
| Ашиглалтын зардал | 4,658,600.00 | | (4,658,600.00) | - |
| Засварын зардал | 8,099,536.36 | 5,205,353.90 | (2,894,182.46) | 64.27 |
| Элэгдэл хорогдлын зардал | 38,903,839.14 | 134,352,087.40 | 95,448,248.26 | 345.34 |
| Түрээсийн зардал | 9,521,484.53 | 1,818,181.82 | (7,703,302.71) | 19.10 |
| Хөдөлмөр хамгаалал, материал, цэвэрлэгээ үйлчилгээний зардал | 19,686,250.00 | | (19,686,250.00) | - |
| Шатахууны зардал | 8,968,195.14 | 2,219,073.67 | (6,749,121.47) | 24.74 |
| Зар сурталчилгааны зардал | 278,600.00 | | (278,600.00) | - |
| Бусад | 8,656,194.60 | 28,084,196.10 | 19,428,001.50 | 324.44 |
| **Дүн** | **282,087,814.78** | **268,956,468.06** | **(13,131,346.72)** | **95.34** |



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН

## 13) Тодруулга – Бусад орлого, зардал

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 -ний үлдэгдэл | 2019/12/31 -ний үлдэгдэл | | Өөрчлөлт Дүн | Өөрчлөлт Хувь |
|---|---|---|---|---|---|
| Харилцах дансны үлдэгдэлд олгосон хүүгийн орлого | 1,719,461.78 | 2,107,353.32 | | 387,891.54 | 18.41 |
| Бусад орлого | 180,000.50 | 381,020.73 | | 201,020.23 | 52.76 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 156,114,971.65 | 65,542,628.04 | | (90,572,343.61) | (138.19) |
| Бусад зардал | (4,207,520.96) | - | | | |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | - | (706,403.18) | | (706,403.18) | 100.00 |
| Дүн | 153,806,912.97 | 67,324,598.91 | - | (86,482,314.06) | (128.46) |

## 14) Тодруулга – Татварын тооцоолол

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018 он | 2019 он | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|
| Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал | 192,617,518.27 | 143,065,290.54 | (49,552,227.73) | 74.27 |
| Тусгайлсан хувь хэмжээгээр Татвар ногдуулах орлого | 1,719,461.78 | 2,107,353.32 | 387,891.54 | 122.56 |
| Хасагдахгүй зардал | (2,738,157.59) | (2,918,084.18) | (179,926.59) | 106.57 |
| **Нийт байнгын зөрүү** | **(1,018,695.81)** | **(810,730.86)** | **207,964.95** | **79.59** |
| Түр зөрүү | 156,114,971.65 | 65,542,628.04 | (90,572,343.61) | 41.98 |
| Нийтлэг хувь хэмжээгээр ТНО | 37,521,242.43 | 78,333,393.36 | 40,812,150.93 | 208.77 |
| Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар | 3,752,124.24 | 7,833,339.34 | 4,081,215.09 | 208.77 |
| Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулсан татвар | 171,946.18 | 210,735.33 | 38,789.15 | 122.56 |
| **Нийт ногдуулсан татварын зардал** | **3,924,070.42** | **8,044,074.67** | **4,120,004.25** | **204.99** |
| **Хойшлогдсон татварын зардал** | **15,611,497.17** | **6,554,262.80** | **(9,057,234.36)** | **41.98** |
| Нийт татварын зардал | 19,535,567.59 | 14,598,337.47 | (4,937,230.11) | 74.73 |



ЮНИСТАР АУДИТ ХХК

**15) Тодруулга – Холбоотой талууд**

Тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани нь өөрийн удирдлага, хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харилцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байна.

Тус компанийн хувьд доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүс холбоотой талууд байна.

| Холбоотой талын нэр | Харьяалал | Холбоо, хамаарал |
|---|---|---|
| Blacktip Energy Limited | Сингапур улсын хуулийн этгээд | Хай Би Ойл ХК хөрөнгө оруулсан |
| Ц.Батбаяр | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Б.Батбаатар | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат гишүүн |
| Б.Мянганбаяр | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат гишүүн |
| Б.Мягмаржав | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат гишүүн |
| А.Батбаяр | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат гишүүн |
| С.Ариунбат | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат гишүүн |
| Б.Лхагвадорж | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат гишүүн |
| А.Харцага | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Т.Тамир | Монгол Улсын иргэн | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Нью Альфа ХХК | Монгол Улсын хуулийн этгээд | Хай Би Ойл ХК-ийн 30-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч |
| Firebird Mongol Holdings | АНУ-ын хуулийн этгээд | Хай Би Ойл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч |
| Firebird Global Master Holdings-2 S.A.R.L | АНУ-ын хуулийн этгээд | Хай Би Ойл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч |
| БиДиСек ХК | Монгол Улсын хуулийн этгээд | Хай Би Ойл ХК-ийн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч |
| Монгол Алтан Минт ХХК | Монгол Улсын хуулийн этгээд | Хай Би Ойл ХК-ийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч |
| Шарын гол ХК | Монгол Улсын хуулийн этгээд | Зэргэлдээ компани |
| Си Би Эм ХХК | Монгол Улсын хуулийн этгээд | Зэргэлдээ компани |
| Ш.Амар-Отгон | Монгол Улсын иргэн | Гүйцэтгэх захирал, Хай Би Ойл ХК |



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН АЛБАНЫ
ХЯНАЛТЫН

**16) Тодруулга – Болзошгүй алдагдал**

**Санхүүгийн тайлангийн тодруулга 2 авлага**-д багтсан Ашид мөнхийн зам ХХК-иас авах 18,923.68 долларын буюу 51,728.3 мянган төгрөгийн хүүгийн авлага, 57,016.9 төгрөгийн асфальтны авлага, нийт 108,745.2 мянган төгрөгийн авлагын төлөгдөх хугацаа 5 хүртэл жилээр хэтэрсэн байна. Ашид мөнхийн зам ХХК нь эзэмшигч солигдсон тул олдоогүй. Дээрх авлагын төлөгдөх боломж, харилцагч байгууллагын төлбөрийн чадварыг үнэлээгүй, авлагын нөөц байгуулаагүй, захирлуудын аман баталгаа, тохиролцоогоор урсгалаараа явснаас болж төлөгдөөгүй байна.

**Санхүүгийн тайлангийн тодруулга 4 Урьдчилж төлсөн тооцоо дансан**-д багтсан үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ёмкостуудтай холбоотой 13,636.4 мянган төгрөгийн урьдчилж төлсөн төлбөрийн тооцоог хийж, бүртгээгүй байна.

**17) Тодруулга – Балансын дараах үйл явдал**

**Санхүүгийн тайлангийн тодруулга 5 өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт**-д багтсан Сингапур улсын хуулийн этгээд болох Блектип Энержи Лимитед компанийн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хурлаар компанийг татан буулгах онцгой шийдвэрийг гаргаж, Грант торнтон Сингапур компанийн 2 ажилтныг татан буулгагчаар томилсон байна. Компанийн татан буулгагчдад Сингапур улсын Компанийн тухай хуулийн дагуу компанийн хөрөнгийн тодорхой хэсгийг гишүүдэд бодит хэлбэрээр хуваарилах эрх олгосон байна. Хай би ойл ХК нь Блектип Энержи Лимитед компанийн нэг бүр нь 0.36 сингапур долларын үнэтэй 3,633,450 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Энэ нь Блектип Энержи Лимитед компанийн нийт энгийн хувьцааны 13 хувь бөгөөд тайлант оны санхүүгийн тайланг гаргах үед хувьцааны талаар шаардлагатай мэдээлэл аваагүй, улмаар үнэ цэнийг тодорхойлоогүй байна. Санхүүгийн тайланд 1,636,952.1 мянган төгрөгөөр бүртгэсэн.

Ингэснээр компани Санхүүгийн тайлангийн тодруулга 5-өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтад дахь 1,636,952.1 мянган төгрөгийн алдагдал хүлээж болзошгүй байна.

**18) Тодруулга – Эрсдэлийн удирдлага**

Компанид санхүүгийн эрсдэл үүсч болох дараах хөрөнгүүд байна.

- Авлага болон зээлийн авлага
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Худалдааны болон бусад өглөг



ЮНИСТАР АУДИТ ХХК
БҮРТГЭЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН
НЭГЭМЖЛЭСЭН

*Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр:*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2018/12/31 | 2019/12/31 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | хувь |
| **Санхүүгийн хөрөнгүүд** | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 51,945,419.62 | 253,039,809.91 | 200,094,390.29 | 485.20 |
| Зээл ба авлага | 1,984,328,998.51 | 1,957,841,681.30 | (26,487,317.21) | 98.67 |
| Өмчийн үнэт цаасарх хөрөнгө оруулалт | 1,636,952,132.00 | 1,691,233,612.00 | 54,281,480.00 | 103.32 |
| Санхүүгийн хөрөнгө | 3,673,226,550.13 | 3,901,115,103.21 | 227,888,553.08 | 106.20 |
| **Санхүүгийн өр төлбөрүүд** | | | | |
| Худалдааны болон худалдааны бус өглөг | 552,138,286.99 | 481,761,356.83 | (70,376,930.16) | 87.25 |

Удирдлага нь компанийн эрсдэлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ түүнийг тодорхойлж, бэлтгэх үүрэгтэй.
Удирдлага компанийн өрсөлдөх чадвар, уян хатан байдалд хэт нөлөөлөхгүйгээр эрсдэлийг аль болох бууруулах бодлого баримтлах хэрэгтэй.

Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын эрсдэл

Компанийн хөрөнгө оруулсан Сингапур улсын хуулийн этгээд болох Блектип Энержи Лимитед компанийн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хурлаар компанийг татан буулгах саналыг гаргаж, Грант торнтон Сингапур компанийн 2 хүнийг татан буулгагчаар томилсон байна. Компанийн татан буулгагчдад Сингапур улсын Компанийн тухай хуулийн дагуу компанийн хөрөнгийн тодорхой хэсгийг гишүүдэд бодит хэлбэрээр хуваарилах эрх олгосон байна. Компанийн хөрөнгө оруулсан Сингапур улсын хуулийн этгээд болох Блектип Энержи Лимитед компани татан буугдах үед учирч болзошгүй эрсдлийн дээд хэмжээ 1,636,952.1 мянган төгрөг байна. Компани 2019 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн тайланг үед хувьцааны талаар шаардлагатай мэдээлэл аваагүй, улмаар үнэ цэнийг тодорхойлоогүй байна.

Өр төлбөрийн эрсдэл

Компани бэлтгэн нийлүүлэгч болон харилцагчдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх учирч болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн дээд хэмжээ 481,761.4 мянган төгрөг байна. Компани өр төлбөрөө ээлж дараатай төлж барагдуулах уян хатан бодлого баримталж ажиллахгүй бол компани төлбөрийн чадваргүй болж, хэвийн үйл ажиллагаа алдагдаж болзошгүй.

**19) Зэрэгцүүлсэн мэдээлэл**

Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн дүнг эдгээр санхүүгийн тайлантай нийцүүлэх зорилгоор зарим мэдээллийг дахин ангилсан болно.

Б.ТЭРБИШ
Юнистар Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2020.04.07